

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

/2019 оны 2 дугаар улирал/

2019 оны 06 дугаар сарын 25

Дархан-Уул аймаг

Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага нь иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхдээ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, 2007 оны 8 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2009 оны 54 дүгээр захирамжаар батлагдсан “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам” болон холбогдох бусад хууль, эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, сум, хэлтэс, агентлагууддаа мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган улирал бүр үнэлэлт, дүгнэлт өгч ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг дараах эх үүсвэрээр хүлээн авч байна. Үүнд:

1. Аймгийн нутгийн захиргааны байгууллагуудаар;
2. “Нийтийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн 70371212 дугаарын нээлттэй утсаар;
3. Дархан сумын “Иргэдэд үйлчлэх төв”, төвийн 70371313 дугаарын утсаар;
4. www.darkhan.gov.mn цахим хуудсаар;
5. Аймгийн болон сумдын ЗДТГ-ын “Иргэд хүлээн авах өрөө”-өөр;
6. Засгийн газрын “11-11 төв”-өөр тус тус өргөдөл, гомдлыг хүлээн авч байна.

2019 оны 2 дугаар улирлын байдлаар Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж 5249 өргөдөл, гомдол ирүүлснээс 4919 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 330 өргөдөл, гомдлын шийдвэрлэх хугацаа болоогүй байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 93.71 хувьтай, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлоос 4952 хүсэлт, 59 санал, 238 гомдол тус тус эзэлж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газарт 335 өргөдөл, гомдол ирүүлснээс 300 иргэний өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 35 иргэний өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хугацаа болоогүй өргөдөл гомдлын шийдвэрлэлт 89.55 хувьтай байна.

Өргөдөл, гомдлын мэдээг нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгавар, зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлэн үйл ажиллагаанд тусгаж, өргөдөл, гомдлын мэдээг улирал бүр www.darkhan.gov.mn сайтад байршуулан ажиллаж байна.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ /2019 оны 2 дугаар улирал/**

2019 оны 06 дугаар сарын 25

Дархан-Уул аймаг

Хүснэгт 1

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэж хариу өгсөн	Шийдвэрлэлт		Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт /%/
				Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн		
1	АЗДТГ-ын дүн	335	300	18	0	35	89.55%
2	Сумдын дүн	2754	2624	1118	0	130	95.28%
3	Агентлагийн дүн	2160	1995	74	0	165	92.36%
ДҮН		5249	4919	1210	0	330	39.71%

Өргөдөл, гомдол, санал, хүсэлт /хэлбэрээр нь/

Хүснэгт 2

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс					Бусад
			Бичгээр	11-11 төвөөр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	
1	АЗДТГ-ын дүн	335	194	0	0	68	73	0
2	Сумдын дүн	2754	2415	0	20	137	182	0
3	Агентлагийн дүн	2160	1922	0	13	114	108	3
ДҮН		5249	4531	0	33	319	363	3

Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн агуулга /%-аар/

Хүснэгт 3

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/
1	Дархан-Уул аймаг	<p>Нийт 5249 өргөдлөөс</p> <p>1. Хүсэлт 4952 93.43%</p> <p>2. Санал 59 1.12%</p> <p>3. Гомдол 238 4.53%</p> <ul style="list-style-type: none"> - Тухайн байгууллагаас үзүүлдэг төрөлжсөн үйлчилгээнд хамрагдахыг хүссэн өргөдөл, гомдол 2082 /39.80%/ - Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдахыг хүссэн 956 /18.21%/ - Газар хүссэн 704 /13.41%/ - Бусад 1507 /28.71%/ <ul style="list-style-type: none"> • Аймгийн Засаг дарга С.Насанбат нь 2019 оны 04 дүгээр сарын 24-ны өдөр аймгийн Залуучууд театрын танхимд 500 гаруй иргэд, хөдөлмөрчидтэй уулзалт зохион байгуулж орон нутагт хийгдэж байгаа хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлаа танилцуулан иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч сонслоо. Мөн 2019 оны 06 дугаар сарын 29-ны өдөр Шарын гол сумын 100 гаруй иргэд хөдөлмөрчидтэй уулзалт зохион байгууллаа. • БНСУ-ын буцалтгүй тусламжаар ирүүлсэн 4 ширхэг түргэний автомашиныг Шарын гол сумын ЭМТөв, аймгийн Нэгдсэн эмнэлгүүдэд хүлээлгэн өглөө. • Дархан сумын 6 дугаар багийн Брак байруудын дахин төлөвлөлтийн 60 айлын орон сууцанд хамрагдах ахмадуудын өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх ажлын хэсгийг томилж, зорилтот бүлгийн 5 ахмадуудад орон сууцаар хангах, 07 дугаар сарын 07-ны өдөр айл өрхүүдэд түлхүүр гардуулж барилгын нээлтийн арга хэмжээг зохион байгуулахаар бэлтгэл ханган ажиллаж байна.

...ooOoo...